

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024.11.01

Даланзадгад сум

Нэг. Улсын бүртгэлийн хууль холбогдох журмуудад тусгуулах саналыг хүргүүлэв.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд:

1. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтад: Энэ хуулийн 6.5-д заасан өргөдөл гаргаагүй, эсхүл эцэг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэр байхгүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол хүүхдийн эхийн овог, нэрээр төрсний бүртгэл хөтөлнө гэж заасан байдаг. Үүнээс “Эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй” гэсэн хэсгийг хасах. Учир нь өмнөх гэрлэлтээ дуусгавар болгоогүй өөр хүнтэй хамтран амьдарч байгаад хүүхэдтэй болсон тохиолдолд эцэг, эхийн тус тусдаа гаргасан өргөдөлийг үндэслэн эцгээр овоглож болох эсэхийг тодорхой оруулах.
2. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад: Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг гэж заасан байдаг. Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д гэрэлхийг хүсэгчид өөрсдийн оршин суугаа газрын эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулсан байна гэж заасан байдаг. Үүнийг байнга оршин суугаа хаяг болон түр оршин суугаа хаягаас эрүүл мэндийн шинжилгээний бичиг авч болох эсэхийг тодорхой болгох. /Жишээ нь: Дорноговь аймгийн иргэн Өмнөговь аймагт гэрлэлтээ батлуулахад Дорноговь аймгаас эрүүл мэндийн шинжилгээний бичиг авах эсвэл Өмнөговь аймгаас эрүүл мэндийн шинжилгээний бичиг авч болох эсэхийг тодорхой болгох/
3. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтад: Гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээ гэж заасан байдаг үүнийг гэрлэлтийн гэрчилгээ гэж оруулах.
4. Эцэг /эх/ тогтоосны бүртгэлд насанд хүрсэн иргэн төрсөн эцгээрээ овоглох тохиолдолд ямар материал бүрдүүлж хэрхэн бүртгэх талаар хууль, журманд тодорхой оруулах. /Жишээ нь: Эцэг, эх нь тус тусдаа амьдарч байгаа, эсхүл эцэг, эхийн хэн нэг нь нас барсан, эсхүл эцэг эхийн хэн нэг нь зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд/

5. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалтад: Эцгийн овог, нэрээр овоглож байсан иргэн эхийн овог нэрээр овоглох, эхийн овог нэрээр овоглож байсан иргэн эцгийн овог, нэрээр овоглох гэж заасан байдаг. /эхийн овог нэрээр овоглож байсан иргэн эцгийн овог, нэрээр овоглох гэдэг нь эцэг тогтоолтын бүртгэл гэж ойлгогдохоор байгаа тул үүнийг тодорхой болгох/
6. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх заалтад: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны овог, эцэг /эх/-ийн нэр өөрийн нэр өөрчлөхийг хориглоно гэж заасан байдаг. Цагдаагийн байгааллагын тодорхойлолтыг хэдэн наснаас дээш авах талаар тодорхой болгох.
7. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад: Иргэн шилжин суурьшихдаа дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суух газрынхаа /сум хорооны/ улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ гэж заасны 10 хоног гэсэн хугацааг хасах учир нь тухайн иргэн зөвхөн шилжин ирж байгаа газраа шууд бүртгүүлдэг болсон. Хасалт хийгдэхгүй байгаа учир хугацаа байх шаардлагагүй.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журамд:

1. Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 4.6 – д гэрлэлт дуусгавар болсныг иргэний улсын бүртгэлд бүртгэсэн бол гэрлэлтийн гэрчилгээнд хүчингүй тэмдэглэгээ хийж, уг гэрчилгээг гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн нотлох баримтад хавсаргана гэсэн заалтыг хасах. Учир нь өөрт байгаа мэдээллийг иргэнээс шаардахгүй иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гэрлэсний бүртгэлийн мэдээллийг шалган лавлагаа үүсгэн бүртгэл хөтөлж байгаа.
2. Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 12.4 – д үрчилсний бүртгэл хөтөлж, үрчилсэн тухай иргэний улсын бүртгэлийн лавлагаа олгоно. Уг лавлагаа үрчилсний бүртгэл хөтөлсөнтэй холбогдуулан төрсний бүртгэлд өөрчлөлт оруулсан мэдээлэлд үндэслэн сольж олгосон төрсний гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байна гэж заасан байдаг. Үүнээс “Үрчилсэн тухай иргэний улсын бүртгэлийн лавлагаа олгоно” гэсэн хэсгийг хасах учир нь үрчилсний бүртгэл хөтөлхөд лавлагаа үүсэхгүй зөвхөн төрсний бүртгэлд өөрчлөлт оруулсан мэдээлэлд үндэслэн төрсний гэрчилгээний олгогдож байгаа.

Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээллэх журамд:

1. 1.4. Их дээд сургууль коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх иргэнийг түр ошин суугчаар бүртгэнэ гэж

заасан байдаг түр оршин суугчаар бүртгэхдээ түр оршин суугчийн үнэмлэх олгох.

2. 2.1.4. Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6.4 дэх заалтад заасны дагуу шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлсэн тэмдэглэгээ хийлгэсэн цэргийн үүрэгтний үнэмлэх гэсэн заалтыг хасах. Учир нь Иргэний улсын бүртгэлийн тухай хуулинд тусгагдаагүй мөн аймаг, нийслэл, сум, дүүрэгт цэргийн алба хариуцсан хэлтэс, нэгжүүд байдаг тул иргэний Улсын бүртгэлд иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэхэд цэргийн үүрэгтний үнэмлэх шаардлагагүй. Иргэдэд хүндрэл, чирэгдэлтэй болно.
3. 5.1. Баг, хорооны Засаг дарга түр оршин суух шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тоон мэдээ, мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан загвар, маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дараа сарын 10 ны өдрийн дотор аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ гэсэн байдаг бөгөөд Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тоон мэдээллийг хүлээн авах шаардлаггүй. Харин статистик хариуцсан байгууллагад хүргүүлэх нь зүйтэй байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд:

1. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “улсын ерөнхий байцаагчийн шийдвэр” гэснийг “улсын байцаагчийн дүгнэлтээр” гэж өөрчлөх
2. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дэх хэсгийг хүчингүй болгох
3. 10 дугаар зүйлийн 10.6 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэхдээ тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын шийдвэрийг үндэслэх” гэж нэмж оруулах
4. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг хүчингүй болгох
5. 0-16 насны хүүхдийн үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах буюу худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалахыг хориглох заалтыг нэмэж оруулах
6. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хүчингүй болгох

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журамд:

1. Журмын 5 дугаар зүйлд “Шинээр баригдсан орон сууц, барилга байгууламжийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэхдээ зөвхөн хөрөнгө оруулалт, захиалга, худалдах, худалдан авах гэрээнд оролцсон этгээдийг өмчлөгчөөр бүртгэх” гэж нэмж оруулах

2. Журмын 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэхдээ хоёр болон түүнээс олон өмчлөгчтэй мэдүүлэх тохиолдолд хамтран өмчлөгчөөр бүртгүүлэх этгээдийн зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлэн мэдүүлэгт хавсаргах” гэж нэмж оруулах

Хоёр. Албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 02 ны өдөр хэлтсийн дарга Ч. Энхмөнх бүх албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалтыг зохион байгуулж, албан хаагчдыг ажилдаа сахилга хариуцлагатай ажиллахыг анхааруулсан. 2024 онд хэлтсийн албан хаагчид ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна.

Гурав. Өмнөговь аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг” мөрийн хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 02 дугаар сарын 21 ны өдөр Цогтцэций сумын Засаг даргын тамгын газарт, 2024 оны 04 дүгээр сарын 29 ны өдөр Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт, 2024 оны 09 дүгээр сарын 05 ны өдөр Гурвантэс сумын Засаг даргын тамгын газарт Улсын бүртгэлийн “ДӨТ” машиныг тус тус байршуулан, хэвийн ажиллагаанд оруулж, 2024 оны 11 сарын 01 ны байдлаар улсын бүртгэлийн лавлагаа 5860, иргэний тоон гарын үсэг олгох үйлчилгээ 2050, иргэний үнэмлэхний захиалга 36, цахим гадаад паспорт 139, улсын бүртгэлийн төлбөр төлөх үйлчилгээ 5273, нийт 13358 улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. 2024 оны 02 сарын 01 ний өдрөөс Улсын бүртгэлийн хэлтсийн байранд 24/7 “ДӨТ” машин ажиллаж байна.

Дөрөв. Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд “Явуулын оффис”-оор Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд улсын бүртгэлийн “Нэг цэг”-ийн үйлчилгээг сард нэг удаа тогтмол зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1500 гаруй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Овоотын цэргийн анги, Шивээ хүрэнгийн боомтон дээр улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэн 200 гаруй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Өмнөговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээр очин тус газарт хоригдож байгаа 1 иргэний гэрлэсний бүртгэл хөтлөн, 4 иргэний цахим үнэмлэхний захиалга авсан.

Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран амжиргааны баталгаажих түвшингээс доогуур, бүтэн өнчин болон хагас өнчин хүүхдүүдийн судалгааг авч нягтлан шалгаж бичиг баримтаа үрэгдүүлсэн болон зөрчилтэй бичиг баримтын зөрчлийг арилган 14 хүүхдийн төрсний гэрчилгээг дахин олгосон.